



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/377

Эрдэнэт

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.”Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 1.1.9.8, 1.1.9.11, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.10 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдлын судалгаа хийж дүгнэлт гаргах, нийгмийн халамж шаардлагатай гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, алслагдсан хүн ам, түр оршин суугчид, сургууль завсардсан хүүхэд зэрэг зорилтот бүлгийн иргэдэд сургалт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх иж бүрэн үзлэг, шинжилгээг явуулын амбулаториор зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардал 14504000/ Арван дөрвөн сая таван зуун дөрвөн мянган/ төгрөгийг “Эрүүл мэндийн тогтолцооны дунд хугацааны стратеги”-ийг боловсруулан хэрэгжүүлэх зардал”-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, тандалт судалгаа, сургалт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх иж бүрэн үзлэг, шинжилгээ хийж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
0200001796

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 29-ний өдрийн
А/377 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТ

№	Нэр	Тоо ширхэг	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
Дэд хөтөлбөрийг танилцуулга				
1	Баннер	2x3	6500	39000
2	Урилга	80	500	40000
3	Дэд хөтөлбөр хэвлүүлэх зардал	6	40000	240000
4	Танилцуулга брошур хэвлүүлэх	150	900	135000
5	Дэд хөтөлбөрийг англи хэл дээр хөрвүүлэн ДЭМБ-д хүргүүлэх	80	1 хуудас х 15000	1200000
Нийт				1 954 000
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх иж бүрэн үзлэгт алслагдсан багийн зорилтод бүлгийн иргэдэд явуулын байдлаар зохион байгуулах				
8	Шатахуун	100 л	1650	165000
9	Үзлэгийн бээлий	10 хайрцаг	8500	85000
10	Эхо гель	10	2000	20000
11	Хурдавчилсан сорил 5 төрөл	483	7500	3622500
12	Жирэмсний тест	100	500	50000
13	1 удаагийн аяга	100	50	5000
14	Аюулгүй хайрцаг	6	1800	10800
15	Тарианы хөвөн	8	500	4000
16	Вакумтеннер	420	500	210000
17	1 гр шпириц	420	100	42000
18	Эмч нарын өдрийн цай	10	4000	40000
Нийт				4 614 300
Сүрьеэгийн явуулын дижитал рентген үйлчилгээ				
19	ХӨСҮТ-ээс дижитал рентген явууллын автомашин ирэх, ажиллах, буцах шатахууны зардал	1000 км/ /100км-20 литр/	1650	330 000
20	Ажиллах эмч, жолооч, техник нарын урамшуулал /5 өдөр/	5 өдөр 3 хүн	80 000	1 200 000
Нийт				1 530 000
Зорилтот бүлгийн хүн амын судалгаа, бүртгэлийн санг бүрдүүлэх, газар зүйн байршлын зураглал гаргах, хувилах				
21	Эх бэлтгэл	1	45000	45000
22	Хэвлэлт	15	14000	210 000
Нийт				255 000
Сургалт сурталчилгаа, бусад				
23	Эх бэлтгэл	4	15000	60000
24	Сургалтын брошур хэвлүүлэх/4 төрөл/	400	1000	400000
25	Сургалтын хэрэглэгдэхүүн /бичгийн цаас, пламастр, бал, ватум цаас,		60000	60000

	принтерийн хор цэнэглэх.../			
26	Цайны зардал /6 удаа х 50 хүн/	300 хүн	1500	450000
27	Зохион байгуулалтын бусад зардал	1	340700	340700
				1 310 700
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдлын судалгаа				
28	Судалгааны мэдээлэл цуглуулах	6 хүн 20 өдөр	8000	960000
29	Судалгаанд оролцогчдын урамшуулал	600	3000	1800000
30	Таниулсан зөвшөөрлийн хуудсыг хувилах	600 ш х 1 хуудас	50	30000
31	Мэдээллийн хуудсыг хувилах	600 х 4 хуудас	50	120000
32	Судалгааг удирдан зохион байгуулах	20 өдөр	20000	400000
33	Мэдээллийг компьютерт шивэх	600ш х 4 хуудас	250	600000
34	Боловсруулалт хийх	2 хүн 5 өдөр	45000	450000
35	Судалгааны тайлан бичих	20 хуудас	2500	50000
36	Судалгааны тайлан хянах	20 хуудас	1500	30000
37	Зорилтот бүлгийн иргэдтэй /алслагдсан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс хоцорч буй/ фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах / цайны зардал/	8 бүлэг 10 хүн	2500	400000
	НИЙТ			4 840,000
	Нийт			14 504 000